



МОНГОЛ ХЭЛНИЙ ӨГҮҮЛБЭРИЙН УТГЫН ХАРЬЦАА

Б. Мөнгөнцэцэг *

Хэлний нэгжүүд нь үүрэг мөн чанараараа бие биеэ нөхөхийн зэрэгцээ бие биетэйгээ эсрэгцэн, дээд түвшний нэгж нь доод түвшнийхээ нэгжийг багтааж, доод түвшний нэгж нь урвуугаар дээд түвшнийхээ нэгжид багтдаг байна. Эдгээр нэгжүүд ийнхүү давхарлан шаталсан тогтолцоог үүсгэхдээ ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн утгатай байна. Энэ нь хэлний нэгжүүдийн ижилсэх ба ондооших ёстой нөхцөлдөж байдаг. М.Базаррагчаа, Ж.Баянсан нар хэлний нэгжүүдийн хоорондох утгын гол харьцааг



Хэлний нэгжүүдийн авианы бүтэц бүрэлдэхүүн нь ялгарч хувьсахын цаад хязгаар нь ойролцоо нэгж байдаг бол нийлж хувьсахын цаад хязгаар нь ижил нэгж (омонимия) юм. Иймээс тэмдэглэхүүний цаад хязгаар болсон ойролцоо нэгжийн дотор авиа утга хоёр төсөөрхөж, төсөөт нэгжийг бий болгодог ажээ. Тэгвэл нийлж хувьсахын цаад хязгаар болсон ижил нэгж (омонимия)-ийн дотор авиа утга хоёр салаалж, салаа утга (полисемия) бий болно². В.В.Виноградов “Үгийн сан-утга зүйн ноён нуруу бол үгс адил болох суурь дэвсгэр болдог” гэж үзсэн байдаг бол үгс болон бусад нэгж өөр болох нь буй. Тэр нь эсрэг ба зүйлчилсэн нэгжүүд болно. Үүнд дээр дурдсан дөрвөн зүйл харьцааг зургаан зүйл харьцаа болгож болно:



Ийнхүү бидний хэлнээ хэлбэрээрээ өөр, агуулгаараа ойр нэгж байхын зэрэгцээ эсрэг нэгж байдаг. Үүний эхнийх нь ойролцоо үг, ойролцоо өгүүлбэр, сүүлчийнх нь эсрэг үг,

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹ Базаррагчаа М., Баянсан Ж. (1997), Монгол хэл уран зохиолын лавлах, Улаанбаатар, 58-63-р тал.

² Ахманова О.С. (1957), Очерки по общей и русской лексикологии. М., стр. 192, 104.


эсрэг өгүүлбэр болно. Мөн хэлбэрээрээ ижил, агуулгаараа өөр нэгж байдаг бөгөөд үүнийг ижил үг, ижил өгүүлбэр гэнэ. Тухайн нөхцөлөөс шалтгаалан уул нэгж хувирдаг. Үүнийг үгийн салаа утга, авиалбарын хувилбар, өгүүлбэрийн хувилбар гэх мэтээр нэрлэдэг.

Эдгээр нэгж нь хэдийгээр өөр өөр нэгж боловч өөр хоорондоо нарийн холбоотой байдаг. Энэ нь дээрх зэрэгцүүлээс тодорхой мэдэгдэнэ. Тодруулбал, ойролцоо өгүүлбэр нь гүн бүтэцдээ санаа нь нэг бол, ижил өгүүлбэрийн санаа өөр байдаг. Тэгвэл өнгөн бүтэцдээ ойролцоо өгүүлбэр хэлбэр нь өөр бол, ижил өгүүлбэр нь хэлбэрээрээ ижил байдаг. Жишээлбэл, *Бурантаг бол бидний дотор хамгийн бие бялдар багатай нь юм* (Ч. Лодойдамба). *Бурантаг бол биднээс хамгийн бие бялдар багатай нь юм.* – *Бидний дотор бие бялдраар хамгийн бага нь Бурантаг юм.* *Бидний дотор бие бялдар хамгийн багатай нь Бурантаг юм.* *Бурантагийн бие бялдар биднээс бага юм.*” гэх мэтээр уул өгүүлбэрийг бүтээж буй өгүүлбэрийн гишүүдийн байр, түүний хэлбэрийг өөрчилсөн ч уул өгүүлбэрийн санаа нь нэг ажээ. Үүнийг тухайн өгүүлбэрийн хувилбар гэж болно. Ийм өгүүлбэрүүдийг Г.А.Золотова ойролцоо өгүүлбэр гэжээ. Тэрээр, орос хэлний “Собака лаёт- Собака лаять- Лай собак” хэмээх өгүүлбэрүүд нь “үйлдэгч- үйл” гэсэн утгыг хадгалах тул ойролцоо өгүүлбэр³ гэж үзсэн байна. Бид ийм өгүүлбэрийг нэг өгүүлбэрээс салаалсан хувилбарууд гэж бодож байна.

“*Бурантаг бол бидний дотор хамгийн бие бялдар багатай нь юм*” – “*Бид Бурантагаас бие бялдраар том билээ*” гэвэл эсрэг утга бүхий өгүүлбэрүүд ажээ. Энэ нь “*Бурантаг бие бялдар бага. Бид бие бялдар том*” гэсэн хураангуй өгүүлбэрийг харьцуулахад тодорхой юм.

“*Бурантаг бол бидний дотроос хамгийн бие бялдар багатай нь юм.* –*Дулмаа биднээс хамгийн жаахан нь юм. Бурантаг гэж хочтой бяцхан охин байлаа*” гэсэн өгүүлбэрүүдийг харьцуулбал санаа нь нэг боловч гишүүдийг чөлөөтэй сольсон байна. Үүнийг ойролцоо өгүүлбэр гэж болох юм.

Хэлэнд агуулга ба гаргалгын тал бүхий эх, өгүүлбэр, үг, бүтээвэр гэсэн үндсэн нэгжүүд байдаг. Хэлний дээд, доод түвшин, тэдгээрийн нэгжүүдийн багтах, багтаах эрэмбэ дэс нь тухайн хэлний нэгжүүдийн хувьд шаталсан тогтолцоог бүрдүүлнэ. Эдгээр нэгжүүд нь үүрэг мөн чанараараа бие биеэ нөхөхийн зэрэгцээ бие биетэйгээ эсрэгцэн, дээд түвшний нэгж нь доод түвшнийхээ нэгжийг багтааж, доод түвшний нэгж нь урвуугаар дээд түвшнийхээ нэгжид багтдаг байна. Хэлний нэгжүүд ийнхүү давхарлан шаталсан тогтолцоог үүсгэхдээ ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн утгатай байна. Хэлний нэгжүүдийн хоорондох утгын гол харьцаа нь хэлний түвшин бүрийн нэгжид түгээмэл тохиолдох учраас



³⁾ Золотова Г.А. (1982), Коммуникативные аспекты русского синтаксиса, М., стр. 51.

гэж загварчилж болох юм. Жишээ нь: Зөвхөн ижилсэх харьцаанд л гэхэд

1.а. *Намрын сайхан сар минь*

Нарт ертөнцийг тойрсоор

Насан өнөдийн хүү минь

Намайгаа үргэлж эргэсээр

Өнгөт сайхан сар минь

Орчлон ертөнцийг дагасаар

Үнэн сэтгэлт хүү минь

Өнчин намайг хүлээсээр (Д.Нацагдорж) (ойролцоо цогцолбор)

б. *Удахгүй дээ, удахгүй, үүр цайна, удахгүй*

Уудам хорвоод наран мандана, удахгүй

Удахгүй дээ, удахгүй, үүд тогшино, удахгүй

Учралт чи минь наддаа ирнэ, удахгүй

Удахгүй дээ, удахгүй, наран мандана, удахгүй

Ургах наран хорвоог гийгүүлнэ, удахгүй

Удахгүй дээ, удахгүй, чи минь ирнэ, удахгүй

Ухаалаг чи минь намайг жаргаана, удахгүй (Б.Явуухулан) (төсөөт цогцолбор)

2.а. *Орчлонд оройтохгүй*

Хорвоод хойшдохгүй (ойролцоо өгүүлбэр)

б. *Усан далай булгаас эхтэй*

Ухаан далай номоос эхтэй (төсөөт өгүүлбэр)

3.а. *хичээх, чармайх, махрах, мачийх, улайх* (ойролцоо үг)


б. *таах, тааварлах, умбах, шумбах, шунгах* (төсөөт үг)

4.а. *-дал, -аас: оё- дол ~ оё- оос, зур- дал ~ зур- аас* (ойролцоо бүтээвэр)

б. *-мгай, -мтгай: түр- мгий, түр- мтгий, цоч- мхой, цоч- мтгой* (төсөөт бүтээвэр)

зэрэг зүйлийг багтааж болно.

Нийлмэл өгүүлбэрийн гол зангилаа зүйл нь тэдгээрийн зааг буюу холбох хэрэглүүр юм. Өгүүлбэр нь заагт байгаа нэгжүүдээр зэрэгцэж угсарч холбогдохоос гадна тухайн өгүүлбэрүүдийн үндэс давтагдах, эсрэгцэх эсвэл ойролцоо ба төсөөтэй болох зэргээр хоорондоо холбогддог. Үүнтэй монгол хэлний өгүүлбэрийн найруулгын сондгойруулахгүйн ёс нарийн холбоотой байдаг. Эрдэмтэн М.Базаррагчаа, Ж.Баянсан нар өгүүлбэрийн найруулгыг хэлбэр⁴ ба агуулгын хувьд ялган үзсэн байна. Тодруулбал, агуулгын хувьд “ойролцоо ба төсөөт өгүүлбэр нь ижилсэлд, эсрэг ба зүйлчилсэн өгүүлбэр нь ондоошилд тус тус тулгуурлана” гэж үзээд, өгүүлбэрийг хэлбэрийн талаас нь тэгшлэх ба эс тэгшлэх гэж хоёр ангилсан байна⁵. Үүнд:



⁴) “хэлбэр” гэдгийг “хэлзүйн ижил төстэй бүтэц” гэсэн утгаар хэрэглэв.

⁵) Базаррагчаа М., Баянсан Ж. (1997), Монгол хэл уран зохиолын лавлах. УБ., 63-р тал.

Хэлний их нэгжийг бага нэгжтэй нь харьцуулан, улмаар агуулга хэлбэр, зогсонги хөдлөнг талаас диалектик харьцаанд нь авч үзэж, тус бүрийн онцлогийг гаргаж болно. Энэ санаанд тулгуурлан утгын нэгэн адил ижилсэх харьцаанд буй монгол хэлний төсөөт өгүүлбэр, ойролцоо өгүүлбэрийг жишээлэн авч үзье.

О.Д.Прокопчик төсөөт үг нь хэлэнд байдаггүй, харин ярианы хэлнээс тольд оруулдаг ба ижил үг, салаа ба ойролцоо утгатай мөргөлдөн байж үүснэ⁶ гэжээ. Төсөөт үгс нь ижил үгтэй хэлбэрээрээ адил боловч утгаараа ялгаатай бол үгийн олон утгатай хэлбэрээрээ адил, утгаараа холбоотой юм. Тэгвэл ойролцоо үгтэй хэлбэр (авиа)-ээрээ ялгарч, ерөнхий утгаараа ижил байдаг. Иймд төсөөт үгс нь дээрх утгын бүх харьцааг агуулдаг. Тиймээс Б.Идэрбаяр төсөөт үгсийг утгаар нь

1) ойролцоо утгатай төсөөт үг (*итгэх-итгэмжлэх*)

2) эсрэг утгатай төсөөт үг (*энд-тэнд, ийм-тийм*)

3) салаа утгатай төсөөт үг (*шавайх-шовойх-шөвийх*)

4) зүйлийн буюу гарлын утгатай төсөөт үг (*балаг-булаг-бэлэг-бүлэг-(полог)*⁷ гэж ангилсан байна. Эрдэмтэн М.Базаррагчаа энэ санаанд тулгуурлан, “Хоёроос дээш зэргэд ба зэргэд бус, энгийн ба нийлмэл өгүүлбэрт цөм өгүүлбэр давтан орвол түүнийг төсөөт өгүүлбэр гэнэ”⁸ гээд, эсрэг ба ойролцоо, зүйлчилсэн ба солбицсон өгүүлбэр гэж ялгасан билээ. Тодруулбал,

1) Адилтгасан төсөөт өгүүлбэр (Цөм бүтцээр ижилссэн боловч дэлгэрүүлэгч гишүүд нь ойролцоо утгатай байна).

Онъсогын түрүү ороо хар

Үлгэрийн түрүү үргэмтгий хар

гэхэд ёгт буюу далд санаагаар “сүүдэр”-ийг хэлсэн ба “ороо-үргэмтгий” гэсэн ойролцоо утгат гишүүд, “онъсогын-үлгэрийн” (учир, начир- загвар дүр нууцлаг зүйлс) гэсэн гишүүдээр ялгарсан боловч сүүдрийн онцлогийг дурдсанаараа ойролцоо санаа бүхий төсөөт өгүүлбэр болно.

2) Эсрэгцсэн төсөөт өгүүлбэр (Цөм бүтцээр ижилссэн боловч дэлгэрүүлэгч гишүүд нь эсрэг утгатай байна).

Сайн эр урдаа шархтай

Муу эр хойноо шархтай

гэхэд “сайн - муу, урдаа - хойноо” гэсэн эсрэг утгат гишүүдээр ялгарчээ.

3) Зүйлчилсэн төсөөт өгүүлбэр (Цөм бүтцээр ижилссэн боловч дэлгэрүүлэгч гишүүд нь өөр өөр зүйлийн утгатай байна).

Хаан хүний хүү хар торгон дээлтэй

Ноён хүний хүү ногоон торгон дээлтэй

гэхэд “хаан - ноён, хар - ногоон” гэсэн гишүүдээр ялгарч, “элэг цөс” хоёрыг онъсоголжээ. Үүнд: “хаан ...хар” гэсэн нь элэг, түүний шинж, “ноён...ногоон” гэсэн нь цөс, түүний шинжийг тус тус өгүүлсэн байна. Ингэж хоёр өөр зүйл (элэг, цөс)-ийг нэг цөм бүтэц (хүү, дээлтэй)-ээр давтан холбожээ.

⁶ Прокопчик О.Д. (2005), Семантические механизмы и прагматические функции паронимии. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Санкт Петербург., стр. 50

⁷ Идэрбаяр Б. (2005), Ойролцоо утга бүхий төсөөт үгс. -“Монгол хэлний төсөөт үг”. Улаанбаатар, 11-р тал

⁸ Базаррагчаа М. (2007), Монгол хэл-9. Улаанбаатар, 124-р тал.

4) Солбицсон төсөөт өгүүлбэр (Тухайн өгүүлбэрийг бүтээж буй төрлийн ба төрлийн бус гишүүд солигдовч уг хоёр өгүүлбэрийн санаа төсөөтэй байдаг).

Мэдлэг бол хүч, Хүч бол мэдлэг гэхэд төрлийн бус өөр өөр гишүүд солигдсон бол

Үгийн өвгөн утгын таяг тулмуу

Утгын өвгөн үгийн таяг тулмуу

гэхэд хоёр өөр төрлийн бус харьяалахын тодотгол солигдсон байна.

5) Ойролцоо санаат төсөөт өгүүлбэр (Давтсан цөм бүтцээс ялгарсан гишүүд нь ойролцоо утгатай бол түүнийг ойролцоо санаат төсөөт өгүүлбэр гэж болно).

Дамын үг далан худалтай

Зуурдын үг зуун худалтай

гэхэд үг худалтай гэсэн эс тусах үйл гишүүнтэй цөм өгүүлбэрээс “дам- зуурд, дал-зуун” (огт худал гэснийг тооны нэрээр хэтрүүлжээ) гэсэн ойролцоо гишүүнээр ялгарсан тул ойролцоо санаат төсөөт өгүүлбэр болно⁹⁾.

Энэ хэмжүүрээр монгол хэлний төсөөт өгүүлбэрийг түүнтэй ижилсэх харьцаанд буй ойролцоо өгүүлбэр болон ондооших харьцаанд буй эсрэг, зүйлчилсэн өгүүлбэртэй харьцуулан авч үзье. Үүнд:

<i>адилтгасан төсөөт өгүүлбэр</i>	<i>cf. хэлэхүүний ойролцоо өгүүлбэр</i>
<p><i>Усан далай булгаас эхтэй</i> <i>Ухаан далай номоос эхтэй</i> (<i>paro.</i>) гэхэд “<u>далай-Ш</u> [<u>эхтэй -Ш</u>]” гэсэн хоёр гишүүнт цөм өгүүлбэр давтан орж, адилтгасан төсөөт өгүүлбэрийг бүтээжээ. Өөрөөр хэлбэл, “далай эхтэй” гэснийг давтсанаар ижилссэн бол “ус, ухаан, булгаас, номоос” гэсэн дэлгэрүүлэгч гишүүдээр ялгарч ондоошсон байна.</p>	<p><i>Өртэй хүн өөдөлдөггүй</i> <i>Өттэй мал таргалдаггүй</i> (<i>syn.</i>) гэхэд төсөөт өгүүлбэрийн адил адилтгалаар бүтсэн (адилтгагдахуун, адилтгахуунаар илэрсэн) хэдий ч цөм бүтэц нь давтагдаагүй тул хэлэхүүний ойролцоо өгүүлбэр болно. Түүнчлэн өөр өөр зүйлийн тухай өгүүлж байгаа ч илтгэх санаа нэг учраас зүйлчилсэн өгүүлбэр бус, харин ойролцоо өгүүлбэр болно. Учир нь, дагалт өгүүлбэр (малын тухай) нь хүний тухай өгүүлсэн өгүүлбэрийн санааг нотлох, хүчжүүлэн чимэхийн зэрэгцээ, адилтгуулагч болжээ.</p>
<i>эсрэгцсэн төсөөт өгүүлбэр</i>	<i>cf. эсрэг өгүүлбэр</i>
<p><i>Муу хүн мундраараа</i> <i>Сайн хүн эрдмээрээ</i> (<i>paro.</i>) гэхэд цөм бүтцээрээ ижилсэн, “сайн- муу, мундар (алдаа осол, шившиг)- эрдэм” гэсэн эсрэг утгат дэлгэрүүлэгч гишүүдээр ялгарсан тул эсрэгцсэн төсөөт өгүүлбэр болно.</p>	<p><i>Явсан хүн яс зууна</i> <i>Хэвтсэн хүн хээл алдана</i> (<i>anto.</i>) гэхэд өгүүлэгдэхүүн гишүүн нь давтагдах боловч шууд тусагдахуун, өгүүлэхүүн нь өөр гишүүдээр илэрсэн тул төсөөт өгүүлбэр болж чадахгүй. Харин “яв-, хэвт-, зуу-, алд-” гэсэн үйл үгээр бүтсэн гишүүдээр эсрэгцсэн боловч “яс зуу-, хээл алд- (таргал-, тур-)” гэсэн хэлц холбоо үгээр ялгарсан тул эсрэг өгүүлбэр болох бөгөөд “Зүгээр суухаар зүлгэж суу, дэрээ элээхээр дэвсээ элээ” гэсэн санаа илтгэнэ.</p>
<i>зүйлчилсэн төсөөт өгүүлбэр</i>	<i>cf. зүйлчилсэн өгүүлбэр</i>
<p><i>Хорхойн мөрөөр хорь хонох</i> <i>Аалзны мөрөөр арав хонох</i></p>	<p><i>Намрын цагт шилд бууж,</i> <i>Өвлийн цагт өтөгт бууж,</i></p>

⁹⁾ Базаррагчаа М. (2007), Монгол хэл-9, Улаанбаатар, 57-58-р тал.

<p>(paro.) гэхэд “дэмий юмаар хөөцөлдөж цаг алдах” гэсэн санааг илтгэхдээ цөм бүтэц ((хүн)-<u>ш</u> [<u>хонох-ш</u>] нь давтагдан, “хорхой- аалз (амьтны зүйл, багасгал), хорь- арав (тооны зүйл, ихэсгэл)” гэсэн зүйлийн үгээр ялгарсан тул зүйлчилсэн төсөөт өгүүлбэр болно.</p>	<p><i>Хаврын цагт нөмөрт бууж, Зуны цагт зүлгэнд буу</i> (field.) гэхэд дөрвөн улиралд хаа хаа буухыг дэс дараалан ахиулж үзүүлсэн тул зүйлчилсэн өгүүлбэр болохын зэрэгцээ өгүүлбэрийн цөм бүтэц нь давтагдаагүйгээрээ зүйлчилсэн төсөөт өгүүлбэрээс ялгагдаж байна.</p>
<p>ойролцоо санаат төсөөт өгүүлбэр <i>Нохойн дуу тэнгэрт хүрдэггүй Оготны дуу огторгуйд хүрдэггүй</i> (paro.) гэхэд <u>дуу</u>- <u>ш</u> [<u>хүрдэггүй- ш</u>]^{X3} гэсэн эс тусах үйл гишүүнтэй цөм өгүүлбэрээс “тэнгэр- огторгуй” гэсэн ойролцоо гишүүнээр ялгарсан тул ойролцоо санаат төсөөт өгүүлбэр болно.</p>	<p>cf. хэлэгдэхүүний ойролцоо өгүүлбэр <i>Харахад царайгүй харчгар Үзэхэд үзэмжгүй үрчгэр</i> (syn.) гэхэд „хар- үз, царайгүй- үзэмжгүй“ гэсэн ойролцоо үг, „харчгар- үрчгэр“ гэсэн төсөөт үг зэрэгцэн, „тэгш хэмээ алдах, гоо үзэмжгүй“ гэсэн санааг илтгэж буй тул ойролцоо өгүүлбэр болох бөгөөд цөм бүтэц эс давтагдсанаараа ойролцоо санаат төсөөт өгүүлбэрээс ялгагдана.</p>
<p><i>Багш нь муу бол Шавь нь муу Шавь нь муу бол Багш нь муу</i> (paro.) гэхэд тухайн өгүүлбэрийг бүтээж буй төрлийн гишүүд (багш/шавь, шавь/багш) солигдовч илтгэж буй санаа нь төсөөтэй тул солбицсон төсөөт өгүүлбэрт оруулж болно.</p>	

<p>paro. <i>Усан далай</i> <u>ш</u> булгаас [<u>эхтэй</u>]^{X3} <i>Ухаан далай</i> <u>ш</u> номоос [<u>эхтэй</u>]^{X3} (metaf.) cf. <i>Өртэй хүн өөдөлдөггүй Өттэй мал таргалдаггүй</i> (syn.)</p>	<p>paro. <i>Муу хүн</i> <u>ш</u> мундраараа <u>ш</u> <i>Сайн хүн</i> <u>ш</u> эрдмээрээ <u>ш</u> cf. <i>Явсан хүн яс зууна Хэвтсэн хүн хээл алдана</i> (anto.)</p>
<p>syn. . poli. .</p>	
<p>paro. <i>Нохойн дуу</i> <u>ш</u> тэнгэрт [<u>хүрдэггүй</u> <u>ш</u>]^{X3} <i>Оготны дуу</i> <u>ш</u> огторгуйд [<u>хүрдэггүй</u> <u>ш</u>]^{X3} (poli.~ syn.) cf. <i>Харахад царайгүй харчгар Үзэхэд үзэмжгүй үрчгэр</i> (syn.)</p>	<p>paro. <u>ш</u>-<u>ш</u> <i>Хорхойн мөрөөр хорь</i> [<u>хонох</u> <u>ш</u>]^{X3} <u>ш</u>-<u>ш</u> <i>Аалзны мөрөөр арав</i> [<u>хонох</u> <u>ш</u>]^{X3} cf. <i>Намрын цагт шилд бууж, Өвлийн цагт өтөгт бууж, Хаврын цагт нөмөрт бууж, Зуны цагт зүлгэнд буу</i> (field.)</p>

Ийнхүү төсөөт өгүүлбэр нь агуулга, гаргалгын хувьд хагас тохирч, мөн хагас ялгарахын зэрэгцээ цөм өгүүлбэр нь давтагддагаараа ойролцоо өгүүлбэрээс ялгагдаж байна.

Энэчлэн ойролцоо өгүүлбэрийг агуулга хэлбэр, зогсонги хөдлөнги талаас диалектик харьцаанд нь авч үзэхдээ ойролцоо үгтэй харгуулан үзэж болно. Бид ойролцоо утгыг дан үгийн жишээн дээр шинжлээд 1) туйлын¹⁰ (1.бүрх = шляп, дэлгүүр = хоршоо, тоншуул = цондуул, 2.хөхөө = хөгөлзөргөнө), 2) оновчтой (1.гомдол ≠ гоморхол, хүмүүнлэг ≠ хүмүүнч, шавар ≠ шавхай, хагалалт ≠ хагалбар ≠ хагарал ≠ хагаралт ≠ хагадас; хагал- ≠ хагач-; 2. хооловч = хүзүүвч, 3. даар- ≠ бээр- ≠ осго- ≠ хөлд-), 3) оновчтой бус (1.өвгөд ≠ өтгөс ≠ дээдэс ≠ урьдас; 2. нөхөр ≠ сүүдэр, хувь ≠ тавилан), 4) хуурмаг (1.унт- ≠ нойрс- # дугжир- ≠ хажуул-, 2. ярь- ≠ өгүүл- ≠ хүүрнэ- # хөөр- ≠ хуучил- # чалч- ≠ бур-)¹¹ гэж ангилсан шиг ойролцоо өгүүлбэрийг 1) туйлын ойролцоо өгүүлбэр (Үйл явдал, санаа хоёрын аль аль нь ижил), 2) оновчтой ойролцоо өгүүлбэр (Үйл явдал нь өөр хэдий ч санаа нь нэг), 3) адилтгасан ойролцоо өгүүлбэр (Үйл явдал нь өөр хэдий ч илтгэж буй санаагаараа ижилсэх бөгөөд ихэвчлэн дан адилтгалаар үүсэхийн зэрэгцээ ёгтлол, егөөдөл, орлол, төлөөллийн ур маяг давхар илэрдэг), 4) баймжит ойролцоо өгүүлбэр (Өөр үйл явдал бүхий ойролцоо өгүүлбэрийг өгүүлэгчээс дүгнэсэн төдийгүй, адилтгасан үйл явдлыг үнэлсэн) гэж ялгаж болмоор байна.

Аман, бичгийн зохиолд хэлэх санааг өгүүлбэр, цогцолборын бүтэц, түүний олон сэлгээ хувилбараар илэрхийлэхдээ тэгшлэн сондгойруулахгүй байх, түүнчлэн санааг онцлон ялгахын үүднээс утга - хэлбэрийн хувьд сондгойруулах эс тэгшлэх төдийгүй, гишүүдийг олшруулах, тонгоргох зэрэг олон аргыг хэрэглэдэг байна. Гагцхүү утга санаа, хэлбэр бүтэц хоёр нь зүй зохист харьцаанд байх ёстой ажээ.

Найруулгын утгын ялгааг гаргахад ойролцоо ба төсөөт, эсрэг ба зүйлчилсэн бүтээвэр, үг, өгүүлбэр, цогцолборыг зөв бүтээх нь чухал юм. Тухайлбал,

<i>Арван гурван наснаас</i>	
<i>Тавин зургаан насыг хүртэл</i>	
<i>Шарын гол ба</i>	
<i>Улаанбаатар хоёрын хооронд</i>	
<i>Дагвын өвсийг зөөж</i>	} зүйлчилсэн өгүүлбэр
<i>Балдангийн түлээг тээсээр</i>	
<i>өдий хүрсэн тул</i>	
<i><u>Зам дахь уул давааг ч андахгүй</u></i>	} ойролцоо өгүүлбэр
<i><u>Энхэл донхлыг ч эндэхгүй</u></i>	
<i>Нүхнээс гарч хошихирох</i>	
<i><u>тарвагыг ч бараг таних</u> бөгөөд</i>	} ойролцоо өгүүлбэр
<i>нисэн өнгөрч одох</i>	
<i><u>шувууг ч төлөв мэднэ</u> (Д.Нацагдорж)</i>	

гэсэн цогцолборт тэрэгч Лувсангийн дөчин гурван жилийн хэрэг явдлыг маш оновчтой хураан өгүүлсэн нь ойролцоо өгүүлбэр (ижилсүүлэх), зүйлчилсэн өгүүлбэр (ондоошуулах)-ийг чадмаг хослуулсанд оршино. Тодруулбал, “зөөх- тээх, уул даваа- энхэл донхол, андахгүй- эндэхгүй, бараг- төлөв, таних- мэдэх” гэсэн ойролцоо ба

¹⁰⁾ туйлын ойролцоо үг- абсолютные синонимы, оновчтой ойролцоо үг- точные синонимы, оновчтой бус ойролцоо үг- неточные синонимы, хуурмаг ойролцоо үг- квазисинонимия

¹¹⁾ Базаррагчаа М., Мөнгөнцэцэг Б. (2011), Монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүн, мэдэхүүн ба хэлэгдэхүүн, хэлэхүүний талаас үзэх нь, “МОНГОЛ СУДЛАЛ”. МУИС. МХСС. Боть XXXIII. 26-р тал.

хувилбар үг, “13- 56, Улаанбаатар- Шарын гол, Дагвын өвс- Балдангийн түлээ, нүхнээс гарч хошхирох- нисэн өнгөрч одох, тарвага- шувуу” зэрэг зүйлийн үгсийг зэрэгцүүлж, санаагаа гүнзгийрүүлсэн байна. Ийм жишээ олныг дурдаж болно.

Одоо Занданбалыг хэн санах билээ. Чухам	
<u>мартагдсан “хорвоо”</u>	<u>орхигдсон “орчлон”</u> \implies ойролцоо өгүүлбэр
хэмээх ёсоор бүрэн хөсөрдөж маргааш үхэх өнөө үхэх нь Занданбалын ганц бие дэх хувийн хэрэгт “нэгэн биений зовлон тул”	
<u>дээш тэнгэр хол</u>	<u>доош газар хатуу</u> \implies эсрэг өгүүлбэр
гэдэг монголын хуучин үлгэрээр хэлэх газар гомдох нөхөргүй нэгэнт өнгөрсөн улирлын дотор хоцров (М.Ядамсүрэн).	

ДУГНЭЛТ

Сүүлийн үед хэлний утга судлал ихээхэн хөгжиж буй нь хэлний нэгжүүдийн утгын бүтэц, хэв шинжийг нээж илрүүлэх өргөн боломжийг нээгдүүлсээр байна. Энэ нь хэлний өөр өөр бүтэцтэй нэгжүүд утга ялгарахын зэрэгцээ утга ижилсэх (нийтлэг болох) асуудлыг нарийвчлан судлахад онцгой учир холбогдолтой байна.

Хэлний бага нэгж нь их нэгжээ агуулдаг, их нэгж нь бага нэгжээ багтаадаг харьцаанд нь тулгуурлан, монгол хэлний өгүүлбэрийн утгын харьцааг авч үзэж болох нь хэлний баримтаас харагдаж байна.

НОМЗҮЙ

- Ахманова О.С. (1957) *Очерки по общей и русской лексикологии*. М.,
 Базаррагчаа М., Баянсан Ж. (1996) *Монгол хэл уран зохиолын лавлах*. УБ.,
 Базаррагчаа М. (2007) *Монгол хэл-9*. УБ.,
 Базаррагчаа М., Мөнгөнцэцэг Б. (2011) *Монгол хэлний ойролцоо үгийг мэдэгдэхүүн, мэдэхүүн ба хэлэгдэхүүн, хэлэхүүний талаас үзэх нь*. -“МОНГОЛ СУДЛАЛ”. МУИС. МХСС. Боть ХХХШ. УБ.,
 Золотова.Г.А. (1982) *Коммуникативные аспекты русского синтаксиса*. Изд. Наука, М.,
 Идэрбаяр Б. (2005) *Ойролцоо утга бүхий төсөөт үгс*. -“Монгол хэлний төсөөт үг”. УБ.,
 Прокопчик О.Д. (2005) *Семантические механизмы и прагматические функции паронимии*. Диссертация на соискание ученой степени кандидата филологических наук. Санкт Петербург.

ANNOTATION

Nowadays, semantic study of language is developing that is giving chances to study semantic structures and types in elements of language. It is concerned with study of assimilation and dissimilation language elements which has different structures.

According to some language facts, based on the relation which the sole or small parts of speech can compromise the complex or bigger parts while the bigger parts include the smaller, it can be seen that relation in sentence meaning in Mongolian language.